Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар

сарын 01-ний өдрийн 09 дугаар

тогтоолын нэгдүгээр хавсралт

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРНООНЫ 2025 ОНЫ

ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо {1}	Хувийн жин {2}
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт {3} (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх{/4}		1	1	
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх {5}		1	1	
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх {6}	0.5	0.5	
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал {7}	0.5	0.5	
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал {8}	0.5	0.5	
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал{9}	0.5	0.5	
Хэсгийн оноо				**4**	**4**	
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх {10} */Гарсан дүгнэлтийг хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо/*		1	1	
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал {11}		1	1	
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал {12}		1	0.5	
Хэсгийн оноо				**3**	**2.5**	
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал {13}		1	1	
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал {14} */Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно/*		1	1	
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал {15}		1	1	
Хэсгийн оноо				**3**	**3**	
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**9.5**	**95**

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар

Сарын 01-ний өдрийн 09 дугаар

тогтоолын гуравдугаар хавсралт

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН “ТАЙЛАНГИЙН МАЯГТ”

НЭГ. Товч танилцуулга
Ховд аймгийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороог Тамгын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн А/83 тоот тушаалаар шинэчлэн байгуулсан. Тус хороо нь 5 гишүүнтэй бөгөөд Хороон дарга Б.Батнасан (Санхүү төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн), нарийн бичгийн дарга Л.Гэрэлмаа (ХЭЗХ-ийн мэргэжилтэн), гишүүн Б.Цагаанцэцэг (Төрийн үйлчилгээ мэдээллийн төв хариуцсан мэргэжилтэн), гишүүн Б.Батцэцэг (Архивын тасгийн сан хөмрөгийн эрхлэгч), гишүүн О.Эрдэнэсүрэн (СТСХ-ийн орлого, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн) нар томилогдон ажиллаж байна.
ХОЁР.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:
Ёс зүйн дэд хороо нь Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/83 дугаар тушаалаар байгуулагдаж, 2024, 2025 оны ажлын төлөвлөгөө боловсруулан, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Улсын их хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг авч ёс зүйн дэд хорооны гишүүд хөтөлбөрийг уншин судалж хэрэгжүүлэх арга хэмжээний талаар төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний тусгагдсан ажлуудаас ЗДТГ-ын Үйлчилгээний ажилтнуудад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагч ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь сэдэвт соён гэгээрүүлэх сургалт зохион байгууллаа. Мөн Төрийн албаны зөвлөлөөс “Бүсчилсэн хөгжил төрийн албаны манлайлал” сэдэвт 2 өдрийн баруун бүсийн зөвлөгөөнд ёс зүйн дэд хорооны 3 гишүүн оролцож санал бодлоо солилцож өөрсдийн мэдлэг чадвараа дээшлүүллээ. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга “Хурдтай хөгжлийн зам” аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг сурталчлах, хүний хөгжлийн бодлоготой уялдуулан шинэ эриний хүний хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлан 5.0 системийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор “Хурдтай хөгжлийн зам” хүний хөгжлийн соён гэгээрүүлэх хөтөлбөрийг “Ухаалаг хөгжлийн академи” боловсруулж, Ховд аймгийн Засаг Даргын Тамгын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал “Ухаалаг хөгжлийн академи” “Төрийн албан хаагчийн манлайлал, ёс зүй” хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Орон нутаг, Монгол Улсын Засгийн газраас 2024-2028 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд ёс зүйтэй, манлайлагч, хурдтай, ухаалаг төрийн албан хаагчдыг хөгжүүлэх, хүний эрхийг дээдэлсэн, иргэдийн итгэлийг хүлээсэн хариуцлагатай, төрийн албаны тогтолцоог бий болгох, чадавхжуулах бодлогын хүрээнд “Төрийн албан хаагчийн ёс зүй, манлайлал” модуль хөтөлбөрийг хэрэгжүүлж үе шаттай сургалтуудыг зохион байгуулж байна. Цаашид төрийн албан

хаагчид, иргэд рүү чиглэсэн арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж 16 сумдын төрийн албан хаагчдад ёс зүйн боловсрол олгох мэдээлэл, сургалт сурталчилгааг хүргэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.

2025 онд нийт 14 байгууллагын 840-890 орчим төрийн албан хаагчийг хамруулсан сургалт зохион байгуулсан байна.

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Засаг Даргын Тамгын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал "Ухаалаг хөгжлийн академи" "Төрийн албан хаагчийн манлайлал, ёс зүй" хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэхээр гэрээ байгуулан манлайлан ажиллаж байна.

Ховд аймгийн Засаг дарга Ёс зүйн дэд хорооны №1 дугаартай Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн Төрийн захиргааны удирдах нэг албан тушаалтныг Төрийн албанй тухай хуульд заасны дагуу "ажлаас нь халах" арга хэмжээ авсан бол аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ёс зүйн дэд хорооны №3, №4 дугаартай дүгнэлтүүдийг тус тус үндэслэн Төрийн захиргааны гүйцэтгэх нэг албан тушаалтан, Төрийн үйлчилгээний хоёр ажилтанд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16.1.2-т заасны дагуу..."Өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах" арга хэмжээг тус тус авч ажилласан байна.

Мөн Ёс зүйн дэд хорооноос Төрийн захиргааны удирдах албан тушаалтанд холбогдуулан гаргасан гомдолд холбогдуулан гаргасан №02 тоот дүгнэлтийг үндэслэн Мөст сумын Засаг дарга тухайн албан тушаалтанд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16.1.2-т заасны дагуу..."Өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах" арга хэмжээнүүдийг тус тус авч ажилласан байна.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

2025 оны ажлын төлөвлөгөө боловсруулан, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас аймгийн Засаг даргын Тамгын Газрын Нийтлэг үйлчилгээний ажилтнуудад "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", Төрийн албан хаагч ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт соён гэгээрүүлэх сургалт зохион байгууллаа.

Мөн Монгол улсын Төрийн албаны зөвлөлөөс **"Бүсчилсэн хөгжил төрийн албаны манлайлал"** сэдэвт 2 өдрийн баруун бүсийн зөвлөгөөнд ёс зүйн дэд хорооны 3 гишүүн оролцож санал бодлоо солилцож өөрсдийн мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Дэд хорооны үйл ажиллагаа, урамшууллын санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн, чадавх бэхжүүлсэн талаар:

Ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшуулал олгох тухай 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/149 дугаартай тушаал гарсан бөгөөд журмын дагуу дэд хорооны нарийн бичгийн дарга 2024 оны 07 дугаар сараас эхлэн урамшуулал авч байна. Харин дэд хорооны бусад гишүүд улирал тутам урамшууллаа аваад явж байсан боловч сүүлийн 3,4 дүгээр улирлын урамшууллыг төсвийн хэмнэлтийн хууль тогтоомжтой холбоотойгоор аваагүй байна.

2025 онд нийт 6 гомдол ирүүлсний 2 гомдлыг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1-д ....ёс зүйн дэд хороо өөрийн байгууллагын албан хаагчийн болон харьяалах байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтны гомдол мэдээллийг хянан шийдвэрлэх... гэж, мөн ёс зүйн хорооны 2024 оны 06 сарын 21-ний өдрийн 10 дугаартай "хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолд заасныг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх ёс зүйн дэд хороонд ирсэн гомдлын 2-ыг нь тус тусын

байгууллагад шилжүүлж, 4 гомдлыг харьяаллын дагуу хүлээн авч хэлэлцэн дүгнэлт гаргаж, арга хэмжээ тооцуулахаар холбогдох байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудад тус тус хүргүүлсэн.

Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын вайбер группэд “Байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих, байгууллагын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх талаар цахим шторк байршуулсан. Мөн “Төрийн албан хаагчийн ёс зүй-иргэдэд үйлчлэх үнэт үндэс” хөлтэй самбар хийж Засаг даргын Тамгын газрын үүдний хэсэгт байршуулж, нөлөөллийн арга хэмжээ авч ажиллалаа.

Монгол Улсын Ёс зүйн хорооноос 2025 онд гүйцэтгэж буй "Төрийн албан дахь ёс зүйн асуудал ба зөрчлийн талаар иргэд болон төрийн албан хаагчдын санаа бодлыг тандах судалгаанд сонгогдож

Төрийн албан хаагчдаас авах судалгаа-1:

Судалгааны зорилго, ач холбогдлыг тайлбарласан танилцуулгыг нийт албан хаагчдад хүргэж, QR код, богино холбоосыг өөрийн байгууллагын дотоод цахим хаяг, дотоод сүлжээ, вайбер группээр түгээсэн.

Манай байгууллага нийт 106 албан хаагчтайгаас энэхүү судалгаанд 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 18:00 цагийн байдлаар 74 албан хаагчийг хамруулласан.

Иргэдээс авах судалгаа-2:

Иргэдээс мэдээлэл цуглуулах ажлыг Хавсралт 2 QR код бүхий хуудсыг хэвлэж иргэдийн үйлчлүүлэх хэсэгт байршуулах, мөн Жаргалант сумын 1 цэгийн үйлчилгээний төв, аймгийн архивын хэлтэс дээр үйлчилгээ үзүүлж буй албан хаагчдаар дамжуулан хүргэж 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 18:00 цагийн байдлаар нийт 68 иргэнээр бөглүүлэн судалгааны хугацаанд багтаан амжилттай зохион байгуулсан.

Судалгааг хариуцсан зохион байгуулсан, тайлан бичсэн ажилтан:
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга Л.Гэрэлмаа, гишүүн Б.Цагаанцэцэг, Б.Батцэцэг нар хамтран хариуцан зохион байгуулж судалгааны тайланг нэгтгэн 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр report@ec.gov.mn цахим хаягаар хүргүүлж хамтран ажиллалаа.

2025 оны 11 дүгээр сарын 17-24-ний өдрүүдэд Монгол Улсын Ёс зүйн хорооноос “Хүндэлье, Энэрье 2025” ёс зүйн нөлөөллийн аяны хүрээнд Аймгийн Засаг даргын Тамгын газрын 106 албан хаагчдын дунд талархлын хайрцаг аялуулан, хамгийн олон талархлын үгс хүлээн авсан албан хаагчийг шалгаруулж ёс зүйн дэд хорооны гишүүдийн зүгээс дурсгалын зүйлээр урамшуулж ажиллалаа.

2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр “Төрийн албаны ёс зүйн төлөв байдал, тандах судалгаа” сэдэвт онлайн сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүд оролцлоо.

Гарсан үр дүн ололт амжилт	**Бэрхшээл**

Дээрх ажлуудыг зохион байгуулахад хамт олны дунд эерэг уур амьсгалыг бүрдүүлсэн. Мөн төрийн албан хаагчид ёс зүйн тухай хуулийг чандлан сахиж, төрийн албан хаагч ёс зүйн зөрчлөөс ангид байх талаар тодорхой хэмжээний ойлголт авч, мэдлэгээ өргөжүүлсэн амжилттай байна.	Дээрх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахад төсвийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотойгоор санхүүгийн бэрхшээл тулгарч байсныг дурдах нь зүйтэй байна.

Санал:

Монгол Улсын Ёс зүйн хороо, Удирдлагын академитай хамтран зохион байгуулдаг ёс зүйн сургагч багш бэлтгэх төлбөртэй сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүд шат дараатай хамрагдан оролцох саналтай байна. Дээрх сургалтад хамрагдсанаар Ховд аймгийн төрийн байгууллагууд болон нийт сумдын төрийн байгууллагын ажилтан албан хаагчдад Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулиар сургалт зохион байгуулан ажиллахад өндөр ач холбогдолтой байх болно.

Шалгах хэсэг:

☑ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.

☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх

☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

ЗДТГ дарга ---------- Х. Баасанхүү

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал /

Ёс зүйн дэд хорооны дарга

СТСХ - ахлах мэргэжилтэн ---------- Б. Батнасан

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал /

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

ХЗЗХ-мэргэжилтэн Л. Ган ---------- Л. Гүнсмаа

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал /

Огноо 2026 оны 01 сарын 02.

БАТЛАВ: ЗДТГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.БААСАНХҮҮ

ХОВД АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЁСЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Агуулга	Хийж хэрэгжүүлэх ажил	УЛИРАЛ				Төсөв /Мянган төгрөгөөр/	Хүрэх үр дүн
			I	II	III	IV		
1	Зохион байгуулалтын чиглэлээр	2025 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулах	+				-	Төлөвлөгөөг батлуулсан байна.
2		Ёсзүйн дэд хорооны хурлыг товлон зарлан хуралдуулах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх	+	+	+	+	-	Хурлын тэмдэглэл
3		Ёсзүйн хорооны үйл ажиллагааны тайлан бэлтгэж, холбогдох газарт танилцуулах		+		+	-	Хагас, бүтэн жилийн тайлан
4	Албан хаагчдын харилцаа хандлага дээшилж, ёс зүй сайжирна.	Ёс зүйн сэдэвтэй контент бэлтгэн хүргэх			+	+	500.0	Контент бэлтгэж албан хаагчдад хүргэсэн байна.
5		Шинэ албан хаагчдад байгууллагын дотоод журам, төрийн албан хаагчийн ёсзүйн дүрмийг таниулах, ёсзүйн баталгаа гаргуулах		+	+	+	30.0	Хариуцлагын гэрээ байгуулсан байна.
6		Үйлчлүүлэгчдэд зориулсан харилцаа хандлагын талаар хуудас гаргаж байршуулах		+	+	+	50.0	Нөлөөллийн арга хэмжээ авсан байна.
7		Ёс зүйн тухай хууль, журам сурталчлах хөлтэй самбар гаргаж байрлуулах			+	+	250.0	Самбар гаргаж сурталчилгааны материал байршуулсан байна.
8		Талархлын хайрцаг ажлуулах				+	50.0	Хамгийн ёс зүйтэй төрийн албан хаагчийг шалгаруулна.
9	Ёсзүйн зөрчлөөс урьдчилан	Албан харилцаа, албан хувцаслалт, харилцаа хандлага сургалт зохион байгуулах			+		1200.0	Захиалгат сургалт хийсэн байна.

10	сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр	Байгууллагын ёс зүйн менежментийн дэд бүтцэд шинжилгээ хийх				+	350.0	Нийт албан хаагчдаас судалгаа авч дүгнэлт гаргана.
11		Байгууллагын цахим хуудсанд ёсзүйн талаарх дүрэм журам, хорооноос зохион байгуулсан ажлын талаарх мэдээ мэдээллийг тухай бүр ил тод мэдээллэх		+	+	+	-	Хийсэн ажлыг нийт албан хаагчдад мэдээллэнэ.
Нийт							**2380.0**	

БОЛОВСРУУЛСАН: ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА Б.БАТНАСАН